



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот


「Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний
бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журамд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар батлагдсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журам”-ын 2 дахь заалтад “2.2.4. Бүртгэлийн санд бүртгэгдсэн жолоочид ID дугаар олгоно”, 4.2 дахь заалтад “4.2.5. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн бүртгэлийн сангаас хасах”, “4.2.6. сүүлийн 3 сар болон түүнээс дээш хугацаанд засвартай зогссон тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хасах” гэж тус тус нэмсүгэй.

2. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан байгууллагын цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэболд/-т, Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Ц.Мягмар/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ОТГОНБААТАР

